

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар
сарын 17-ны өдрийн 411 дугаар
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Батпүрэв (аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв
журам хамгаалах тасгийн дарга)

Д.Лхагважав (аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
Таримал ургамлын үр сорт, хорио цээрийн хяналтын
улсын ахлах байцаагч)

Д.Мөнхтуяа (аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч)

С.Пагамзүгсмаа (аймгийн Стандартын хэмжил зүйн
Хэлтсийн Бүтээгдэхүүн баталгаажуулалтын
мэргэжилтэн)

Ц.Сонинбаяр (аймгийн Эрүүл мэндийн газрын
Халдварт бус өвчний асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Б.Ууганбаяр (Монголын үндэсний худалдаа аж
үйлдвэрийн танхимын Өвөрхангай аймаг дахь
салбар танхимын дарга) (зөвшилцсөөр)

Нарийн бичгийн дарга: Б.Анхбилэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/142

Арвайхээр сум


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийг тус тус үндэслэн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллаж байгаа ажилтан нь “Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээ”-ний сургалтанд хамрагдсан байх бөгөөд дээрх ажилчдад сургалт явуулах, гэрчилгээ олгох чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Журмын дагуу сонгон шалгаруулалтыг үр дүнтэй зохион байгуулж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний цэгүүдэд согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (А.Отгонцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0242

D:My Doc. Zahiramj. Zasag darga